



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/618

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "б", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн номын санд тавилга, тоног төхөөрөмж худалдан авах ажлыг гүйцэтгэгч "Содзул" ХХК-ний ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Даваадорж – Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Д.Нямдорж – Боловсрол, соёл, урлагийн газрын  
төсвийн мэргэжилтэн

Б.Сонинтуяа – Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн


Т.Эрдэнэтуяа – Нийтийн номын сангийн эрхлэгч

Нарийн бичгийн

дарга: Г.Жавзанхорлоо – Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

2. Ховд аймгийн номын санд тавилга, тоног төхөөрөмж худалдан авах ажлын гүйцэтгэгч "Содзул" ХХК-ний ажлыг захиалагчаас баталсан ажлын даалгаварын дагуу шалгаж хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

Zax A/618 Ch

02 2302